

ФАТФ-ЫН МЭДЭГДЭЛ

2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын хяналтад орсон улс орнууд өөрсдийн тогтолцоон дахь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдлаа арилгах чиглэлээр ФАТФ-тай идэвхтэй хамтран ажиллаж байна. ФАТФ-ын хяналтад орсон улс орнууд илэрсэн стратегийн дутагдлаа тогтоосон хугацаанд, түргэн шуурхай засч залруулах үүрэг хүлээдэг. Энэхүү хяналтад орсон улс орнуудын жагсаалтыг ихэвчлэн “саарал жагсаалт” гэж нэрлэдэг.

ФАТФ-аас дор дурдсан улс орнуудтай үргэлжлүүлэн хамтран ажиллаж, илэрсэн стратегийн дутагдлыг арилгах чиглэлээр авсан арга хэмжээний талаар цаашид мэдээлсээр байх болно. Мөн эдгээр улс орнуудыг үйл ажиллагааны төлөвлөгөөгөө тогтоосон хугацаанд түргэн шуурхай хэрэгжүүлэхийг уриалж байна. ФАТФ нь улс орнуудын өгсөн үүрэг амлалтыг талархан хүлээн авч, цаашид дутагдлаа арилгах чиглэлээр авсан арга хэмжээнд хяналт тавьж ажиллах болно. ФАТФ-аас эдгээр улс орнуудад харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхийг шаарддаггүй хэдий ч, өөрийн гишүүн улс орнуудыг эрсдэлийн дүн шинжилгээ хийхдээ дараах мэдээллийг харгалзаж үзэхийг зөвлөж байна.

ФАТФ-ын зүгээс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх тогтолцоондоо стратегийн дутагдалтай улс орнуудыг нэмж илрүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийх бөгөөд зарим улс орнуудын үнэлгээг хараахан хийгээгүй байна.

ФАТФ-аас хяналтад орсон улс орнуудыг КОВИД-19 цар тахлын үр нөлөөг даван туулахад анхаарч байгааг нь харгалзан үзэж, энэхүү чуулган дээр гаргасан ахиц дэвшлээ тайлагнахгүй байх сонголтыг өгсөн. Энэ хүрээнд Албани, Ботсвана, Камбож, Гана, Мавритус, Пакистан, Зимбабве улсууд ахиц дэвшлээ тайлагнасан. Харин Барбадос, Ямайка, Мьянмар, Никарагуа, Панам, Уганда улсууд тайлан ирүүлэхээ хойшлуулав. Эдгээр улс орнуудын талаар 2020 оны 2 дугаар сард мэдэгдэл гарсан бөгөөд үүнд эдгээр улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны талаарх хамгийн сүүлийн үеийн мэдээллийг агуулаагүй байж болно.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнууд:	Стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гарсан улс орнууд:
Албани Багамын арлууд Барбадос Боствана Камбож Гана Ямайка Маврикий Мьянмар Никарагуа Пакистан Панам Сири Уганда Йемен Зимбабве	Исланд Монгол

ФАТФ-ын хяналтаас гарсан улс орнууд

Монгол Улс

ФАТФ-аас Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах чиглэлээр томоохон ахиц, дэвшил гаргаж ажилласныг сайшааж байна. Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр нөлөөг бэхжүүлж, 2019 оны 10 дугаар сард ФАТФ-аас илрүүлсэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдлыг арилгахтай холбоотой үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан амлалтаа биелүүлж, холбогдох техникийн дутагдлыг арилгасан байна. Монгол Улс Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгтэй мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах чиглэлээр цаашид үргэлжлүүлэн хамтран ажиллах болно.

ФАТФ-аас гаргасан мэдэгдэлтэй дараах холбоосоор орж танилцана уу.

[Jurisdictions under Increased Monitoring – 23 October 2020](#)